

Өсвөр үе залуучуудад үндэсний өв соёл, тоглоом наадгайг

түгээн дэлгэрүүлэх 2018 оны үйл ажиллагааны тайлан

2018.11.15

Амардалай

2018 оны 02 сарын 23-нд Өсвөр үе залуучуудад үндэсний өв соёл, тоглоом наадгайг түгээн дэлгэрүүлэх 2018 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Шагайн харваан дугуйланд хамрагдахаар нийт 34 хүүхэд бүртгүүлсэн. Сур харвааны дугуйланд нийт 39 иргэн хамрагдаж байна. Сур харвааны хичээлийг аймгийн сур холбооны дэд дарга Анхбаяраар ахлуулсан баг ирэн хичээллэж, сумын сурын холбоог байгуулан цаашид сумын сурын холбоо нь сургалт зохион байгуулж байна.



Шагайн харваан дугуйланг аймгийн гоц мэргэн Г.Сосорбурам, П.Түвшинсайхан нар зааж сургаж байна. Шагайн харвааны дугуйлангийн хүүхдийн дунд 2018 оны 12 сарын 01-нд тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөөд байна.



Сур харваагаар хичээллэж буй Г.Бямбабаяр, Б.Нарантунгалаг, Б.Цагаангэр, Н.Базаррагчаа, З.Наранмандах, Б.Иш-Ёндон, Б.Жанчивдорж, С.Загдсүрэн нар Дэрэн, Говь-Угтаал, Эрдэнэдалай, Хулд, Луус, Дэлгэрцогт сумын баяр наадмаар мөн Говийн бүсийн харваа, суманд зохион байгуулагдсан Бүсийн Хаалтын харваанд амжилттай оролцлоо.



Н.Базаррагчаа нь Дэрэн сумын баяр наадмаар 3-р байранд шалгарч Сумын гоц харваач, Хулд сумын баяр наадмаар 1-р байранд шалгарч Сумын Мэргэн, Дэлгэрцогт сумын баяр наадмаар 3-р байранд тус тус шалгарсан амжилт үзүүлсэн.

С.Загдсүрэн нь Дэрэн сумын баяр наадмаар 3-р байранд шалгарч Сумын гоц харваач, Б.Жанчивдорж Луус сумын баяр наадмаар 3-р байранд шалгарч Сумын гоц харваач, З.Наранмандах Говийн бүсийн харваанд багийн харваагаар 3-р байранд, Г.Бямбабаяр нь Эрдэнэдалай сумын баяр наадмаар хүүхдийн харваанд 1-р байр, Сайнцагаан сумын баяр наадмаар 3-р байр, сумын баяр наадмын хүүхдийн харваанд 3-р байранд тус тус амжилт гаргасан.

2018 оны 10 сарын 07-нд сумандаа Бүсийн Хаалтын харвааг аймгийн Үндэсний сурын холбоотой хамтран зохион байгууллаа.